

Харгалант сумын газрын хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж, энэ ажлын хүрээнд Алтанбулаг, Сэргэлэн, Баянцогт, Жаргалант зэрэг сумдыг 4-6 жилийн дунд хугацааны "Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө"-тэй болгох зорилгоор газрын суурь судалгааны ажлыг эхлүүлсэн байна.



ТӨВ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
12 ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 03

Зуунмод

Г Аймгийн газар зохион байгуулалтын т
талаар 2015 онд хийсэн ажлыг дүгнэж,
2016 онд хийх ажлын чиглэл батлах тухай

Аймгийн газар зохион байгуулалтын талаар 2015 онд хийсэн ажлын биелэлт, 2016 онд хийх ажлын чиглэлийн тухай аймгийн Засаг дарга Д.Баярбатын мэдээлэл, өргөн мэдүүлсэн төсөл, хурлын Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хорооны дүгнэлтийг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

“Аймгийн газар зохион байгуулалтын талаар 2015 онд хийх ажлын чиглэл”-д тусгагдсан газрыг зүй зохистой, оновчтой бүрэн ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх ажлыг Газрын тухай болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж хэрэгжүүлсэн байна. Зуунмод сумын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хийлгэж, гудамж, зам, талбайг засаж сайжруулах зорилгоор гудамж төслийг хэрэгжүүлж эхлэн, иргэдийн орон сууцны асуудлыг шийдвэрлэх зорилгоор газрын дуудлага худалдаа зохион байгуулсан байна.

Лүн суманд “Сумын төвийн шинэчлэл” төслийг хэрэгжүүлэн, “Хаягжуулалтын тухай хууль”-ийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулсан зэрэг аймаг суманд бүтээн байгуулалтын үйл ажиллагаа явуулахад холбогдох газрын харилцааны асуудлыг тухай бүрт нь шийдвэрлэсэн байна.

Газрын Харилцаа, Геодизи Зураг зүйн газартай хамтран Жаргалант суманд газар ашиглалтын тохиромжтой байдлын болон нийгэм, эдийн засгийн хэрэгцээт байллын үнэлгээний суурь судалгааг хийжээ. ХААИС-ын Агро биологийн сургуультай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж, энэ ажлын хүрээнд Алтанбулаг, Сэргэлэн, Баянцогт, Жаргалант зэрэг сумдыг 4-6 жилийн дунд хугацааны “Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”-тэй болгох зорилгоор газрын суурь судалгааны ажлыг эхлүүлсэн байна.

Сумын газрын даамлуудын боловсрол мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарч тэдний сургалт семинарыг 3 удаа зохион байгуулж, улсын хэмжээнд хэрэгжүүлж байгаа “Лэнд менежер” программыг ашиглах анхан шатны мэдлэг олгож, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажилласан байна. Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх

0100053

хуулийн дагуу 2015 онд 5861 иргэнд шинээр газар өмчлүүлснээр хууль хэрэгжиж эхэлснээс хойш аймгийн дүнгээр 37779 иргэнд 7455.0 га газрыг өмчлүүлээд байна.

Газрын дуудлага худалдааг 16 суманд зохион байгуулсан бөгөөд газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөг ханган биелүүлэхэд анхаарал тавьж ажилласны дүнд 2015 онд 1 тэрбум 727,9 сая төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлж төлөвлөгөөгөө 110.3 хувиар биелүүлжээ.

Аймгийн газар зохион байгуулалтын талаар 2015 онд хийсэн ажлыг өмнөх оныхтой харьцуулахад зохих ололт, амжилт байгаа боловч цаашид Газрын тухай хуулийн 33.1.2 дахь заалтыг бүх сумдад хэрэгжүүлэх, иргэдэд газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлэх, тариалангийн талбайн хөрсний үржил шимийг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг тодорхой төлөвлөж хэрэгжүүлэх, газрын төлбөрийн ногдуулалтыг бүрэн хийх, дутуу төлөлтөд алданги тооцож хураан барагдуулах ажлыг улам сайжруулан ажиллах шаардлагатай байна.

“Аймгийн газар зохион байгуулалтын талаар 2016 онд хийх ажлын чиглэлд аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хийх суурь судалгааны ажлыг оновчтой зохион байгуулж бэлтгэл ажлыг бүрэн хангах, иргэнд, ялангуяа Зуунмод сумын иргэдэд газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлж ажиллах, газар эзэмшүүлэх ажлыг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх зэрэг ажлууд тусгагдсаныг тэмдэглээд “ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “з”, 19.1, “Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын арван хоёрдугаар Хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн газрын харилцааны талаар 2015 онд хийх ажлын зорилтууд 90 хувийн биелэлттэй байх тул “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2. “Аймгийн Газар зохион байгуулалтын талаар 2016 онд хийх ажлын чиглэл”-ийн төсөлд Төлөөлөгчдийн гаргасан саналыг тусган хавсралтын ёсоор баталсугай.

3. Энэ тогтоолын 2 дугаар заалтаар баталсан “ Аймгийн Газар зохион байгуулалтын талаар 2016 онд хийх ажлын чиглэл”-ийг хэрэгжүүлэх зорилгоор дараах арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Баярбат/-д даалгасугай.

3.1. “Аймгийн Газар зохион байгуулалтын талаар 2016 онд хийх ажлын чиглэл”-д тусгагдсан зорилт арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийн байдлыг сумдад шалган шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажиллах

3.2. Сумдын газар зохион байгуулалтын 2016 оны төлөвлөгөөнд тусгагдсан газар, өмчлүүлж, эзэмшүүлж, ашиглуулах ажлыг Газрын тухай хуулийн 33.1.2 дахь заалтын дагуу зохион байгуулж хэвшүүлэх, сумдын Засаг дарга нарын өмнөх онуудад

газар эзэмшүүлсэн захирамжуудыг хянан үзэж, илэрсэн зөрчлийг таслан зогсоож, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч байх.

3.3. Сумдад зохион байгуулах газрын дуудлага худалдааг нийтэд ил тод, шударга зохион байгуулж байх, үйл ажиллагаанд нь хяналт тавьж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж ажиллах

3.4. Зуунмод сумын иргэд, аж ахуйн нэгжүүдэд эзэмшүүлэх, өмчлүүлэх газрын хэмжээ байршлыг батлагдсан төлөвлөгөө, чиглэлийн дагуу Сэргэлэн, Зуунмод сумдын удирдлагатай хамтран шийдвэрлэж байх

3.5. Иргэдийн эрх ашгийг хүндэтгэн үзэж ёс зүйн эрхийн дагуу байгалийн баялаг, ан амьтныг гэрээгээр эзэмшүүлж газрыг хамгаалах, унаган төрхийг хадгалах ажлыг эрчимжүүлэх

3.6. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг аймгийн бүртгэлтэй болгох ажлыг үргэлжлүүлэн дуусгах

3.7. “Хаягжилтийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, шинээр бий болж байгаа хороолол, гудамжийг хаягжуулах

3.8. Байгалийн баялаг ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд зарцуулах хөрөнгөнөөс газар, ялангуяа бэлчээрийн газрыг хамгаалах арга хэмжээнд тэргүүн ээлжинд хуваарилахаар төсөвт тусгуулж байх

4. Энэ тогтоолыг өөрийн суманд хэрэгжүүлэх, хэрэгжилтийн байдалд хяналт үнэлгээ хийж шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хуралд зөвлөсүгэй.

5. Энэ тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.МЭНДСАЙХАН

Аймгийн ИТХ-ын 2016 оны 03 дугаар сарын 23 -ний
 өдрийн Арванхоёрдугаар хуралдааны 23 дугаар
 тогтоолын хавсралт.

ТӨВ АЙМГИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР 2016 ОНД ХИЙХ АЖЛЫН ЧИГЛЭЛ

Нийтлэг үндэслэл:

- Газрын харилцааны талаар баримтлах чиглэлийг боловсруулахдаа Монгол улсын Засгийн газрын 2012-201 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Газрын харилцааны шинэтгэлийг хийх”, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх “Үндсэн чиглэл”, “аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг баримт бичгийг үндэслэн холбогдох хууль, тогтоомжуудыг удирдлага болгон боловсруулсан болно.
- 2016 онд хийгдэх газрын харилцааны талаар баримтлах чиглэлийг батлан хэрэгжүүлснээр Газрын нэгдмэл сангийн ангиллын менежментийг сайжруулж, төлөвлөлтийг газрын суурь судалгааны үндсэн дээр иргэд, аж ахуйн нэгжийн саналд тулгуурлан, аймаг, сумын эдийн засгийн хөгжилд түлхэц болохуйц үр ашигтай, өгөөжтэй байхаар хийж, хэрэгжилтэд нь тавих хяналт үнэлгээг мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор гүйцэтгэн, биелэлтийг иргэд, олон нийтэд ил тод мэдээлдэг болгоход оршино.

Төв аймгийн 2016 онд газрын харилцааны талаар баримтлах чиглэлийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

Д/д	Дэвшүүлсэн зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах эзэн
1.	Сумдын 2016 оны Газар зохион байгуулалтын төлөвлөлтийг аймгийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан хийх талаар мэргэжлийн удирдлагын дэмжлэг үзүүлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	1.1 Сумдын 2016 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж, дүнг улирал бүр нийтэд мэдээлж байна. 1.2 Сумдад газар, байгалийн нөөц эдэлбэрийн зүй ёсны эрхийг бүртгэн баталгаажуулах, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах ажлыг орон нутгийн удирдлагууд болон газрын даамлууд холбогдох бусад мэргэжилтэнтэй хамтран зохион байгуулна. 1.3 Сумдын 2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хийхэд ГХБХБГазраас дэмжлэг тусалцаа үзүүлж төлөвлөлтийг олоогийн шаардлагад нийцсэн суурь судалгааг үндэслэсэн иргэдийн оролцоог нэмэгдүүлсэн төлөвлөлтийг зохион байгуулна. 1.4 Сумдын газрын даамлын чадварыг сайжруулах сургалтыг 2 удаа зохион байгуулах. “Лэнд менежер” программд холбож техник хангамжийг шинэчлэх ажлыг төсөл хэрэгжүүлэгчтэй хамтран зохион байгуулна.	ХБХэлтэс, ГХБХБГазар, Сумдын ЗДТГ

		1.5Цээл, Баянчандмань сумын 4-6 жилийн газар зохион байгуулалтын дунд хугацааны төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар хийлгэж хүлээн авах түүнд шаардлагатай хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлнэ. 1.6Сумдын газрын нэгдмэл сангийн тайланг тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн, дүгнэлт гаргуулсны үндсэн дээр аймагт нэгтгэж, тайлангаар гарсан сөрөг үзүүлэлтийг сайжруулах төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллана.	
2.	Аймгийн иргэн бүрт газар өмчлүүлэх асуудлыг шийдвэрлэж өмчилсөн газраа санхүүгийн эргэлтэнд оруулах бодит боломжийг бүрдүүлнэ.	2.1 2016 онд өмчлүүлэх газрын хэмжээ байршлыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж баталгаажуулна. 2.2 Аймгийн газар өмчилж аваагүй байгаа нийт иргэдэд өмчлүүлэхэд шаардагдах газрын хэмжээг тодорхойлон, байршлыг тогтоож, тухайн сумын хамгаалалтанд авна. Энэ ажилтай уялдуулан газрын нөөцөөс хамруулан нэг иргэнд өмчлүүлэх газрын хэмжээг шаардлагатай сумдад шинэчлэн тогтоох ажлыг зохион байгуулна. 2.3 Зуунмод сумын иргэдэд өмчлүүлэх газрын хэмжээ, байршлыг Сэргэлэн сумын нутагт тогтоож газар зохион байгуулалт хийж шаардагдах дэд бүтцийн тооцоо судалгааг гаргаж өмчлүүлэх ажлыг эхлүүлнэ.	ХБХЭлтэс, ГХБХБГазар, Сумдын Засаг дарга
3.	Аймгийн нутаг дэвсгэрт байгаа нийгмийн эзэмшлийн газрыг гэрчилгээжүүлэх ажлыг зохион байгуулж дуусгана.	3.1 Зарим сумын төв, суурин газар тэг гортигийг шинэчлэн тогтоох, авто замын дагуу иргэдэд өмчлүүлж болох газрын байршлыг тогтоож хилийг баталгаажуулах арга хэмжээ авах ажлыг үргэлжлүүлнэ. 3.2 Гудамж, талбайн тохижилт, арчилгаа хийлгэх ажлыг газар эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн хариуцлагын гэрээнд тусгах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	ХБХЭлтэс, ГХБХБГазар, Сумдын Засаг дарга
4.	Шинээр батлагдсан “Хаягжуулалтын тухай” хуулийг орон нутагт сурталчлан сум орон нутагт байрлаж байгаа гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгөнд хаяг олгох дэс дараалсан үйл ажиллагаанд хуулийн дагуу шинэчлэл хийж эхлэнэ.	4.1 Сумдын нутаг дэвсгэрт байгаа орон нутгийн чанартай төв болон салаа замуудыг тэмдэгжүүлэх ажлыг технологийн дараалал, батлагдсан төлөвлөгөөний дагуу үргэлжлүүлнэ. 4.2Аймгийн төвийн сумын гудамж талбай, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулна.	ХБХЭлтэс, ГХБХБГазар, Сумдын Засаг дарга
5.	Газар өмчлөгч, эзэмшигч иргэд, хуулийн этгээдийн газар ашиглалтын байдалд Газрын тухай	5.1 Аймгийн ГХБХБГазраас холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмшил, ашиглалтын байдалд шалгалт хийж зөрчлийг арилгана.	ХБХЭлтэс,

	хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хянан шалгаж, зөрчлийг арилгах арга хэмжээ авна.	5.2 Сумдаас газар олголтын талаар гарч байгаа захирамж, хурлын шийдвэрүүдийг ГХБХБГазарт улирал бүр татан авч дүгнэлт хийж хууль, тогтоомж зөрчсөн эрхийн актыг Газрын тухай хуулийн 61 дүгээр зүйлийг үндэслэн хүчингүй болгуулах, шаардлагатай нөхцөлд аймгийн Засаг дарга бүрэн эрхийнхээ дагуу хүчингүй болгож, тогтоосон журам зөрчиж газар олгосон сумын Засаг дарга, газрын даамал нарт холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллана. 5.3 Газар эзэмшигчийн газарт кадастрын хяналтын хэмжилтийг сумын холбогдох албан тушаалтан, иргэдийн хүсэлтийг үндэслэн хийнэ.	ГХБХБГазар, Сумдын Засаг дарга
6.	Газрын төлбөрийн орлого болон дутуу төлөлтийг барагдуулах ажлын зохион байгуулна.	6.1 Аймгийн ИТХ-ын 2015 оны 8 дугаар хуралдааны 04 дүгээр тогтоолоор батлагдсан газрын төлбөрийн хэмжээг орон нутагт мөрдүүлж аймгийн төсвийн орлогын хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллана. 6.2 Газрын төлбөрийн ногдуулалтыг шалган дүгнэх, нлэрсэн зөрчлийг арилгах, газрын төлбөрийн тооцоо нийлэн дутуу төлөлтийг тодорхойлон акт үйлдэн баталгаажуулж, хууль тогтоомжийн дагуу торгууль, алданги тооцох, төлөвлөгөөт газрын төлбөр, дутуу төлөлтийг бүрэн хураан барагдуулж төсөвт төвлөрүүлэх, тооцоог цахим хэлбэрт оруулах арга хэмжээ авна. 6.3 Аймгийн ИТХТ-ийн 2012.07.04-ний өдрийн 77 дугаар тогтоолын дагуу 2003.01.01-ний өдрөөс хойш газрын дуудлага худалдаа, төсөл шалгаруулалтгүй хууль зөрчин олгосон газраас тухайн үед мөрдөгдөж байсан аргачлалын дагуу дуудлага худалдааны анхны үнээр тооцож, төсөвт бүрэн төвлөрүүлэх ажлыг аймгийн Засаг даргын 2013 оны А/448 тоот захирамжийн хүрээнд хэрэгжүүлнэ. 6.4 Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн судалгааг гаргаж, удирдлагуудтай нь уулзалт зохион байгуулж, орон нутгийн иргэдийн эрх ашиг, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхаар эрх олгож, гэрээ хийж гэрчилгээжүүлнэ. Газрын төлбөрийг бүрэн барагдуулж аймгийн төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллана. 6.5 Газрын биржийн цахим системийг турших ажлыг зохион байгуулж, хэрэглээнд нэвтрүүлнэ.	ХБХэлтэс, ГХБХБГазар, Сумдын Засаг дарга
7.	Бэлчээрийг зүй зохистой ашиглах, хадлангийн талбайн ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авна.	7.1 Бэлчээрийн газрын хэмжээ, даанцыг тодорхойлон дүгнэлт гаргаж, авах арга хэмжээ тодорхойлж, хэрэгжүүлнэ. 7.2 Бэлчээр ашиглалтын нөлөөлөлд фото мониторингийн аргаар хяналт хийх аргачлалыг нэвтрүүлэх, бэлчээрийн доройтлыг сум бүрээр гаргаж сайжруулах, өнжөөх, сэлгэх уламжлалт аргыг шинжлэх ухааны үндэслэлтэй хослуулан хэрэглэж, заавар зөвлөмж гарган хэрэгжүүлэх. энэ талаар Газрын нэгдмэл сангийн тайланд бодитой тусган, цааннд авах арга хэмжээг оновчтой тодорхойлно.	ХБХэлтэс, ГХБХБГазар,

Mv doc: Tooteol 2016-I uliral.

		7.3Бэлчээрийг зүй зохистой ашиглах, өнжөөж ашиглах, ашиглагдаагүй байгаа бэлчээрийг усжуулж ашиглах ажлыг зохион байгуулна. 7.4 Хадлангийн талбайг Газрын тухай хуулийн 53.5 дахь заалтын дагуу иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр эзэмшүүлэх ажлыг үргэлжлүүлнэ. 7.5Аймгийн газрын нэгдмэл санд бүртгэлтэй хадлангийн талбайг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэж баталгаажуулна. 7.6 Багийн түвшинд бэлчээрийн зураглалыг улирал бүр хийж бэлчээрийн дааныг зөв тодорхойлж, хуваарьтайгаар ашиглах төлөвлөгөө боловсруулан мөрдөж ажиллана. 7.7 Огогтно устгах ажлын үр дүнг дээшлүүлэх зорилгоор хил залгаа сумдыг хамруулж бүсчилсэн байдлаар зохион байгуулна.	Сумдын Засаг дарга
8.	Тариалангийн талбайг зүй зохистой, бүрэн хэмжээгээр зориулалтын дагуу ашиглах, хамгаалах арга хэмжээ авна	8.1Тариалангийн зориулалтаар олгогдсон газрыг зориулалтын дагуу бүрэн ашиглаж байгаа эсэхэд судалгаа хийж 2-оос дээн жил болон зориулалтын дагуу ашиглаагүй, төлбөр төлөөгүй газар эзэмшигчийн газар эзэмших эрхийг хууль тогтоомжийн дагуу цуцлуулах, эзэмшилгүй байгаа тариалангийн талбайг хүсэлт гаргасан, зохих шаардлага хангаж буй иргэн, аж ахуйн нэгжид эзэмшүүлж, газар эзэмших гэрээнд зориулалтын дагуу ашиглах, зориулалт өөрчилсөн тохиолдолд авах арга хэмжээг тодорхой тусгаж мөрдөн, тариалангийн талбайн ашиглалтыг сайжруулна. 8.2Тариалангийн газрын ашиглалтыг сайжруулж эзэмшилд байгаа боловч зориулалтын дагуу ашиглагдахгүй байгаа талбайн судалгаа гаргаж ашиглах арга хэмжээг зохион байгуулж ажиллана. 8.3Тариалангийн бүс нутагт бэлчээр, тариалангийн талбайн хортон шавьж, мэрэгчидтэй тэмцэх ажлыг газар эзэмшигчдийн оролцоотойгоор зохион байгуулна. 8.4Тариалангийн талбайн агрохимийн болон агрофизикийн захиалгат хянан баталгааг газар эзэмшигч нараар бүрэн хийлгүүлж, шаардлагатай арга хэмжээг авч, хяналт тавьж ажиллана. 8.5Газар тариалангийн талаар баримтлах Аймгийн бодлогод тусгагдсан Тосны ургамал (ранс) тариалах талбайг хязгаарлах арга хэмжээ авч ажиллана. 8.6Тариалангийн тухай хуулийг хэрэгжүүлж "Тариалангийн бүс нутаг" тогтооход шаардагдах тооцоо судалгааг хийж, төсөл боловсруулна.	ХБХэлтэс, ГХБХБГазар, Сумдын Засаг дарга

		8.7Тариалангийн талбайн захын мал бэлчээх, өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа байхыг хориглосон талбайн хилний зааг, хэмжээг тогтоож, зураглалыг гаргаж, эзэмшигчийг нь тодорхой болгож, өвөлжөө, хаваржааг нүүлгэх зардлын асуудлыг Тариалангийн тухай хуулийн дагуу шийдвэрлүүлнэ.	
9.	Хот суурингийн ангиллын газрыг зохистой ашиглах ажил зохион байгуулна.	9.1Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө нь хийгдсэн сумд төлөвлөгөөгөө хэрхэн мөрдөн ажиллаж байгааг шалган үзэж, зөрчлийг арилгах арга хэмжээ авч, заавар зөвлөмжөөр хангаж, иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулна. 9.2Баянжаргалан, Дэлгэрхаан сумдын төвийн хот төлөвлөлтийн ерөнхий төлөвлөгөөг хүлээн авна, Сэргэлэн, Баянцагаан сумдын ерөнхий төлөвлөгөөг шинээр хийлгэнэ. 9.3Зуунмод хотын ерөнхий төлөвлөгөөг хүлээн авч, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган сумын ИТХ-аар батлуулна. 9.4Зуунмод хотын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан, шаардлагатай зарим байрлалд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийж эхлүүлнэ. 9.5Зуунмод хот болон зарим сумдад үйлдвэр технологийн парк байгуулах газрыг үргэлжлүүлэн олгоно. 9.6“Шинэ нисэх онгоцны буудал”, “Аж үйлдвэрийн парк”, “Богд хаан” төмөр зам зэрэг шинэ бүтээн байгуулалтын төслүүдийг хэрэгжүүлэгч яам, агентлагтай зөвшилцөн хамтран ажиллаж, газар эзэмшүүлэх асуудлыг тухай бүрд нь шийдвэрлэж ажиллана.	ХБХэлтэс, ГХБХБГазар, Сумдын Засаг дарга
10.	Уул уурхайн газрыг зохистой ашиглах, нөхөн сэргээх ажил зохион байгуулна.	10.1 2016-2020 онд “Аймгийн уул уурхай, эрдэс баялгийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж эхэлнэ. 10.2 Уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас хөндөгдөж эвдрэлд орсон, нөхөн сэргээсэн, нөхөн сэргээгдээгүй үлдсэн, эзэнгүй орхигдсон газрын хэмжээг эцэслэн тогтооно. 10.3 Уул уурхайн үйлдвэрлэлийн явцад хөндөгдсөн газрын нөхөн сэргээлтийг чанартай сайн хийлгэж газар дээр нь шалган үзэж стандартын шаардлага хангасан нөхцөлд хүлээн авна. 10.4 Шинээр хайгуулын тусгай зөвшөөрөл олгох мэдэгдэл санал өгөхөд харьяалах багийн удирдлага, малчид иргэдийн төлөөллийг өргөн оролцуулж саналыг нь тусгана.	17 ХБХэлтэс, ГХБХБГазар, БОАЖГазар, МХГ, Сумдын ЗДТГ

		10.5 Аймгийн нутаг дэвсгэрт олгогдсон ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн тооллого хийж, эзэмшигтэй нь тохиролцон гэрээ, хэлцэл байгуулж газрын төлбөр ногдуулж хураан барагдуулах ажлыг зохион байгуулна. 10.6 Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй талбай, олборлож байгаа ашигт малтмал /хайрга, дайрга, элс, боржин зэрэг/-ын хэмжээ болон хэрэгцээний судалгаа гаргаж дүгнэлт хийн, энэ төрлийн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үндэслэл болгоно. 10.7 Энэ төлөвлөгөөний 10.6-д заасныг үндэслэл болгон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул хийх, олборлолт явуулах зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулж, түүний дагуу хайгуулын үйл ажиллагаа явуулах газар эзэмшүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.	
11.	Ойн сан болон Усан сангийн газрыг хамгаалах арга хэмжээ авна.	11.1 Ойн санг хамгаалах арга хэмжээ авч гэрээгээр эзэмшиж байгаа нөхөрлөлүүдийн үйл ажиллагаанд дүгнэлт өгөх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна. 11.2 Усан сангийн газрын /гол, горхи, усны эхийг хашаажуулсан/ хамгаалалтын байдалд хяналт шинжилгээ хийж шинэчлэх шаардлагатай хашаа, хамгаалалтыг засах, шинээр хамгаалах арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. 11.3 Ойн сан бүхий газарт нутагнсан ан амьтан хамгаалах, ховордсон ан амьтан шинээр суурьшуулах төсөл, хөтөлбөрийг нутгийн иргэдийн оролцоотой зохион байгуулна.	ХБХэлтэс, ГХБХБГазар, БОАЖГ, Сумдын Засаг дарга
12.	Зам, шугам сүлжээний газрын хэмжээг нарийвчлан тодотгож, төлбөрт хамруулах ажлыг өргөжүүлнэ.	12.1 Сум бүрийн авто зам, шугам сүлжээний газрын хэмжээг нарийвчлан тодотгож, Газрын нэгдмэл сангийн тайланд бүрэн тусгаж газрын төлбөр ногдуулах түүнийг хурааж төсөвт оруулах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулна. 12.2 Транзит тээврийг нэмэгдүүлэх зорилгоор Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хурдны замыг барьж байгуулах ажлыг хийж гүйцэтгэхэд аймгийн нутгаар дайран өнгөрөх газрын асуудлыг шийдвэрлэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулна. 12.3 Олон улсын онгоцны буудлын авто замын ажлын трассыг хянаж зам барих болон замд шаардагдах хайрга дайрганы газрын асуудлыг шийдвэрлэнэ.	ХБХэлтэс, ГХБХБГазар, Сумдын Засаг дарга
13.	Газрыг хамгаалах ажлыг сайжруулна.	13.1 Талхлагдалд орж болзошгүй газрын судалгааг үргэлжлүүлэн хийж газрын хэмжээ, байршлыг сумдад хүлээлгэн өгч хамгаалах, ашиглалтанд нь тавих хяналтыг өндөржүүлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.	ХБХэлтэс,

		13.2Бэлчээрийн үлийн цагаан оготны тархалтын байдлаас шалтгаалан холбогдох байгууллагуудтай хамтран устгалын ажлыг зохион байгуулна.	ГХБХБГазар, ХААГ, Сумдын Засаг дарга
		13.3Тарналангийн газрын оготно устгалыг тариалан эрхлэгчдээр хийлгэх ажлыг зохион байгуулна.	
14.	Хилийн цэсийн маргаантай байгаа сумдын асуудлыг шийдвэрлүүлнэ.	14.1Нийслэл хоттой хил залгаа сумд болон, Зуунмод сумын хилийн цэсийн асуудлыг шийдвэрлүүлэх ажлыг холбогдох газарт тавьж шийдвэр гаргуулах ажлыг үргэлжлүүлнэ.	ХБХэлтэс, ГХБХБГазар
15.	Хууль сурталчлах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	15.1Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг албан байгууллага, иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулна.	ГХБХБГазар
		15.2Сумдын 2016 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг аймгийн болон ГХБХБГазрын вэб сайгд байрлуулж олон нийтэд ил тод мэдээлнэ	
16	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах бэлтгэл ажлыг хангана.	16.1 Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг үндэслэн уг төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах шаардлага, үндэслэлийг тодорхой болгож холбогдох суурь судалгааг хийж, шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлно.	ГХБХБГазар
		16.2Аймгийн нутаг дэвсгэрээс улсын тусгай хэрэгцээ, хамгаалалтад авсан газарт орсон иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшиж байгаа газрын хэмжээ, заагийг тогтоож, нөхөн олговор олгуулах асуудлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.	

— ооо —

